



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
“ДАРХАН-УС СУВАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 дадар

Дугаар 1/02

Дархан-Уул аймаг

Журам батлах тухай

Монгол Улсын “Компаний тухай хууль”-ийн 83 дугаар зүйлийн 83.1, Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн “Ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам”-ыг хавсралтаар батласугай.
2. Дээрх журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.
3. Энхэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/04 тоот тушаалын 7 дугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ЭРДЭНЭБАТ





ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
“ДАРХАН-УС СУВАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 8/173

Дархан

Г
Журмын заалтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын “Компаний тухай хууль”-ийн 83 дугаар зүйлийн 83.1, Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн “Ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам”ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг “Хөдөлмөрийн тухай хуулийн болон компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны үр дүнгийн урамшууллыг зөвхөн тухайн шийтгэл хүлээлгэсэн сард нь олгохгүй” гэж өөрчилсүгэй.

2. Дээрх журмын өөрчлөлтийг холбогдох ажилтнуудад танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хуулийн хэлтсийн Ахлах, сургалт чанарын мэргэжилтэн (О.Мэндбаяр), Хуулийн зөвлөх, гэрээний мэргэжилтэн (Ж.Нарандорж) нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ЗАХИРАЛ
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БУЯНДЭЛГЭР



"Дархан-Ус суваг" ХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн
1/02 тоот тушаалын хавсралт

АЖИЛТНУУДЫН САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Компанийн тухайн сарын үйлдвэрлэлийн болон эдийн засаг, санхүүгийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулсан ажилтнуудад үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2 Хөдөлмөрийн гэрээ болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалттай биелүүлсэн, үр ашгийг дээшлүүлсэн, идэвхи санаачлагатай, хөдөлмөрийн сахилга баттай ажилласан ажилтнуудад сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгоно.

1.3 Хөдөлмөрийн тухай хуулийн 64.3 дугаар зүйлийн дагуу "туршилтаар ажиллах ажилтан"-д энэхүү журам нэгэн адил үйлчилнэ.

1.4 "Сарын үр дүнг дүгнэх үзүүлэлт"-ийг хавсралт хүснэгтээр батлах бөгөөд энэхүү журмын салшгүй хэсэг болно. Үүнд:

1.4.1 Хүснэгт 1. "Удирдах ажилтнууд"-ын үр дүнгийн үзүүлэлт

1.4.2 Хүснэгт 2. "_____ хэлтэс"-ийн үр дүнгийн үзүүлэлт

1.4.3 Хүснэгт 3. "_____ албаны"-ийн үр дүнгийн үзүүлэлт

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1 "Нэмэгдэл хөлс" гэж ажилтны тухайн сарын үйл ажиллагааны үр дүнгээс хамааруулан олгож буй хөлс,

2.1.2 "ХАБЭА-н зөрчил" гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхуйг,

2.1.3 "Үүрэг даалгаврын биелэлт" гэж ажилтны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн ажил үүрэг болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын үр дүн,

2.1.4 "Хөдөлмөрийн сахилга бат" гэж ажил үүргээ хэрэгжүүлэх явцад заавал дагаж мөрдөх компанийн дотоод хэм хэмжээг сахин биелүүлж буй байдал,

2.1.5 "Ажлын цаг ашиглалт, шуурхай зөвлөгөөнд оролцсон байдал" гэж ажлын цаг ашиглалтыг Able бүртгэлд бүртгүүлсэн эсэх, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцсон эсэх,

2.1.6 "Усны бичилтийн төлөвлөгөөний биелэлт" гэж байцаагч тус бүрт ногдсон биет хэмжээний төлөвлөгөө биелэгдсэн эсэх,

2.1.7 "Авлага үзүүлэлт" гэж байцаагч тус бурийн авлага эхний үлдэгдлээс нэмэгдсэн эсэх

ГУРАВ. САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДҮГНЭХ, ТООЦОХ АРГАЧЛАЛ

3.1 Энэхүү журмын хавсралтаар батлагдсан үзүүлэлтийн дагуу хэлтэс, албаны сарын үйл ажиллагааны үр дүнг холбогдох албан тушаалтнууд дүгнэнэ.

3.2 Сард олгох нэмэгдэл хөлсний хэмжээг дараах байдлаар тооцно. Үүнд:

3.2.1 Гүйцэтгэх захирал, Дэд захирал ерөнхий инженер 300,000 төгрөг,

3.2.2 Хэлтэс, албадын дарга, Дотоод хяналтын мэргэжилтэн, ХАБ-ын инженер, эдийн засагч 250,000 төгрөг,

3.2.3 бусад ажилтнууд 200,000 төгрөг байна.

3.3 Дүгнэгдсэн оноог, ажилласан хоногоор хувилж, нэмэгдлийг тооцож олгоно.

3.4 Хүснэгт 1,2,3-ыг дүгнэх үзүүлэлт

3.4.1 Зардлын гүйцэтгэлийг Эдийн засагч сар бүр гаргана.

3.4.2 Ажлын үнэмлэх ашиглах журам УАЖ-ЗУХХ-09-2021-ийн 4.1.2-4.1.24 дүгээр заалт, 4.2.1-4.2.8 дүгээр заалт, 4.4.1-4.4.5 дугаар, заалтуудын аль нэгийг зөрчсөн ажилтанд ХАБЭА-н харгалзах урамшуулал олгогдохгүй.

3.4.3 Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй тохиолдолд харгалзах урамшуулал олгогдохгүй.

3.4.4 Сард 1-ээс дээш цагаар ажлаас хоцорсон болон тасалсан тохиолдолд урамшуулал олгогдохгүй. Өглөө болон оройны шуурхайд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1-ээс дээш удаа суугаагүй бол харгалзах урамшуулал олгогдохгүй.

3.4.5 Усны бичилтийн төлөвлөгөөний биелэлт (биет хэмжээгээр) төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бол урамшуулал олгогдохгүй.

3.4.6 Сарын эхний авлагын үлдэгдлээс авлагын эцсийн үлдэгдэл нэмэгдсэн бол харгалзах урамшууллыг авахгүй.

3.5 Үзүүлэлт дүгнэх албан тушаалтан:

3.5.1 Захиргаа аж ахуйн болон албадуудын зардлын ёсөлт бууралтыг Эдийн засагч;

3.5.2 ХАБЭА-н зөрчил гаргасан ажилтнуудын мэдээллийг ХАБ-ын инженер;

3.5.3 Ажилтнуудын ажлын цаг ашиглалтын байдлыг Дотоод хяналтын мэргэжилтэн;

3.5.4 Хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн ажилтнуудын талаарх мэдээллийг Дотоод хяналтын мэргэжилтэн тус тус танилцуулна.

3.5.5 Сарын үр дүнгийн урамшуулал олгох хурлыг сар бүрийн ажлын сүүлийн өдрийн өглөөний шуурхай хурлаар хэлэлцүүлж, компанийн Захирлын зөвлөлийн хурлаар оруулж баталгаажуулна.

ДӨРӨВ. САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛС, ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ

4. Ажилтанд дараах тохиолдолд сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй. Үүнд:

4.1 Тухайн хэлтэс, албаны ажилтан үйлдвэрлэлийн осол, аваар гэмтэлд өртсөн тохиолдолд харьяалагдах нэгжийн нийт ажилтанд сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй.

4.2 Хөдөлмөрийн тухай хуулийн болон компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны үр дүнгийн урамшууллыг зөвхөн тухайн шийтгэл хүлээлгэсэн сард нь олгохгүй.

4.3 Заалтад гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар өөрчлөлт орсон/

4.4 Ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн нь тогтоогдсон тохиолдолд нэмэгдэл хөлс олгохгүй.

4.5 Өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгосон эсхүл ажилтан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс ажлаас халагдсан нөхцөлд тухайн ажилласан сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1 Ажилтны сарын үйл ажиллагааны ажлын үр дүнг дүгнэхдээ шударга, ил тод бодитой үнэлэх зарчмыг баримтална.

5.2 Ажилтны ажлыг шударга бус дүгнэсэн, дүгнэх үзүүлэлтийг хожимдуулсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх ба тухай сарын нэмэгдэл хөлс олгохгүй болно.

УДИРДАХ АЖИЛТНУУДЫН САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ УР ДУНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Албан тушаал	Цэвэр усны алдагдал						Бохир усны алдагдал					
		Алба, захираганы зардлын есөлт, бууралт			Үүрэг даалгаврын биелэлт			Ажлын цаг ашигпалт, шуурхай зөвлөгөөнд оролцсон байдал			Хөдөлмөрийн сахилга бат		
ХАБЭА-н зерчил													
1	Захиргаа удирдлага хуулийн хэлтсийн дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
2	Бодлогоо төлөвлөлтийн хэлтсийн дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
3	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
4	Усан хангажийн албаны дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
5	Ариутгах татууртын албаны дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
6	Нийтлэг үйлчилгээний албаны дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
7	Орон сууц хэрэглэгчийн албаны дарга	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
8	Лабораторын эрхлэгч	10	30	20	20	10	10	100	100	100	100	100	100
Ногдох урамшуулалт		25,000	25,000	75,000	50,000	50,000	25,000	25,000	25,000	25,000	25,000	25,000	250,000
Дүгнэх албан тушаалтан		Горим тооцроны инженер	Эдийн засагч	Дэд захирал, ерөнхий инженер	ДХМ	Дэд захирал, ерөнхий инженерд ХМ	ХАБ-ЫН инженер Эрүүл мэнд хариуцсан Маргажилтэн	НИЙТ					

ЗАХИРГАА АЖ АХҮЙН АЖИЛТНУУДЫН САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Хэлтэс	Үүрэг даалгаврын биелэлт					Хөдөлмөрийн сахилга бат
		Хөдөлмөрийн сахилга бат					
Ажлын цаг ашиглалт					ХАБ, ЭА-н зөрчил	Нийт	
ХАБ, ЭА-н зөрчил							
1	Захиргаа удирдлага хуулийн хэлтэс	30	20	40	10	100	
2	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	30	20	40	10	100	
3	Санхүү бүртгэлийн хэлтэс	30	20	40	10	100	
Ногдох урамшуулал (Төгрөг) ХАБ-ын инженер, эдийн засагч,		75,000	50,000	100,000	25,000	250,000	
Дотоод хяналтын Мэргэжилтэн		60,000	40,000	80,000	20,000	200,000	
Ногдох урамшуулал (Төгрөг) Бусад ажилтнууд							
Дүгнэх албан тушаалтан							
Хэлтсийн дарга		ДХМ	ДХМ	ХАБ-ын инженер			
Хэлтийн дарга				Эрүүл мэнд хариуцсан			
Мэргэжилтэн				Мэргэжилтэн			

ХУЧЭГТ 3.

АЛБАНЫ САРЫН УЙЛ АЖИЛЛАГАНЫ ҮР ДҮНГИН ҮЗҮҮЛЭН

Албан тушаал							д/д
	Авлагын үзүүлэлт			Усны бичилтийн төлөвлөгөөний биелэлт (биет хэмжээгээр)			
	Үүрэг даалгаврын биелэлт			Хөдөлмөрийн сахилга бат			ХАБ, ЭА-н зөрчил
	Албаны дарга	ДХМ	ДХМ	ХАБ-ын инженер	Эрүүл мэнд хариуцсан	Мэргэжилтэн	Нийт
1 Инженер техникийн ажилчид		40	40	30	20	30	100
2 Байцааг нар					20	20	100
3 Бусад ажилчид				30	20	30	100
Ногдох урамшуулал (төгрөг) Инженер техникийн ажилчид				60,000	40,000	60,000	200,000
Ногдох урамшуулал (төгрөг) Байцаагч	80,000	80,000			40,000		200,000
Ногдох урамшуулал (төгрөг) Бусад ажилчид		60,000	40,000	60,000	40,000	40,000	200,000
Дүгнэх албан тушаалтан							

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН: ЭДИЙН ЗАСАГЧ

Л.ЮУНДАРЫ

ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
ЗУХХ-ИЙН ДАРГА

Т.БҮЯНДЭЛГЭР А.БАТГӨР Д.УРАНЧИМЭГ Г.АЛТАНШАГАЙ